



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/268

Булган сум

“Итгэлтэй утас” суурилуулах ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1, 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэг, 39 дүгээр зүйлийн 39.1.3 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны IV хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд 16 сум, 1 тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдардаг хүүхдүүдийн хэрэгцээнд зориулсан “Итгэлтэй утас” суурилуулах ажлыг зохион байгуулсугай.

2. Ерөнхий боловсролын сургуулиудын дотуур байранд “Итгэлтэй утас” суурилуулах ажлыг чанартай хийж гүйцэтгэхийг “Монголын цахилгаан холбоо” ХК Булган аймгийн Холбооны газарт үүрэг болгосугай.

3. Дээрх ажлыг хийж гүйцэтгэхэд шаардагдах 15,701,400 (арван таван сая долоон зуун нэг мянга дөрвөн зуу) төгрөгийг хүүхэд, хөгжил хамгааллын хөтөлбөр, арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР